



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар АР10

Хэрлэн сум

### Мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 12, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд зудын гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд зарцуулах 2350 кг хлорын шохойг худалдан авахад шаардагдах 16,450,000 (арван зургаан сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, Халдваргүйтгэлийн бодисын тээвэрлэлт, сумдад хуваарилан олгох ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л. Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ